

**ПАРЛАМЕНТЫН БҮГД НАЙРАМДАХ УЛСУУДЫН ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОН
ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙГ СОНГОХ ЗАРЧИМ**

№	Улс	Ерөнхийлөгчийг хэрхэн сонгодог	Хууль тогтоох дээд байгууллага(парламент)-ыг хэрхэн сонгодог	
			Доод танхим	Дээд танхим
1	Австри	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
2	Бангладеш	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
3	Болгар	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
4	Босни-Герцеговин	Бүх нийтийн сонгуулиар /энгийн олонхын саналаар/ сонгоно.	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
5	Ботсван	Парламентаас сонгоно. /Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна./	Шууд сонгуулиар	Үе залгамжлах болон томилох
6	Вануату	Сонгогчдын коллеги, эсхүл сонгуулийн хорооноос сонгоно.	Шууд сонгуулиар	
7	Герман	Сонгогчдын коллеги, эсхүл сонгуулийн хорооноос сонгоно.	Шууд сонгуулиар	Муж улсын төлөөллөөс
8	Грек	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
9	Доминика	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар болон томилдог	
10	Ирак	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
11	Ирланд	Бүх нийтийн сонгуулиар /энгийн олонхын саналаар/ сонгоно.	Шууд сонгуулиар	Намаас нэрийн жагсаалтаар томилдо
12	Израиль	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
13	Исланд	Бүх нийтийн сонгуулиар /энгийн олонхын саналаар/ сонгоно	Шууд сонгуулиар	
14	Итали	Сонгогчдын коллеги, эсхүл сонгуулийн хорооноос сонгоно.	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
15	Кирибати	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
16	Кыргызстан	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
17	Латви	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
18	Ливан	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
19	Ливи	Парламентаас сонгоно.	Төлөөлөгчдийн зөвлөлөөс сонгоно	
20	Маврикий	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
21	Мальт	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
22	Македон	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
23	Маршаллын Арлууд	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
24	Микронез	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
25	Молдав	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
26	Монгол	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
27	Науру	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
28	Өмнөд Африк	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
29	Пакистан	Сонгогчдын коллеги, эсхүл сонгуулийн хорооноос сонгоно.	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
30	Сан-Марино	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
31	Самоа	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
32	Сингапур	Бүх нийтийн сонгуулиар /энгийн олонхын саналаар/ сонгоно.	Шууд сонгуулиар	
33	Серби	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
34	Словак	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. Олонхын саналаар-2 шат бүхий	Шууд сонгуулиар	

		сонгуулийн тогтолцоотой/		
35	Словени	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	Сонирхлын бүлгийн төлөөллөөс
36	Сомали	Парламентаас сонгоно.	Шилжилтийн тогтолцоотой байга	
37	Суринам	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
38	Тринидад Тобаго	Сонгогчдын коллеги, эсхүл сонгуулийн хорооноос сонгоно.	Шууд сонгуулиар	Томилдог
39	Тунис	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
40	Турк	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
41	Непал	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
42	Унгар	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
43	Фижи	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
44	Финланд	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
45	Хорват	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
46	Чех	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
47	Чрна Гора	Бүх нийтийн сонгуулиар сонгоно. /Олонхын саналаар-2 шат бүхий сонгуулийн тогтолцоотой/	Шууд сонгуулиар	
48	Швейцар	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
49	Энэтхэг	Сонгогчдын коллеги, эсхүл сонгуулийн хорооноос сонгоно.	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
50	Эстони	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	
51	Этиоп	Парламентаас сонгоно.	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар

Эх сурвалж: “Дэлхийн улс орнуудын төрийн удирдлагын хэлбэр, парламентын засагтай орнуудын сонгуулийн зарчим” судалгааны тайлан, УИХТГ, Судалгааны эмхэтгэл-21 боть, 2015 он

Судалгаанд улс төрийн ардчилсан дэглэм бүхий Парламентын Бүгд Найрамдах засагтай 51 орны Ерөнхийлөгч болон Парламентын гишүүнийг сонгох зарчмыг харьцуулан авч үзсэн болно. Судалгаанаас үзэхэд:

Хууль тогтоох дээд байгууллага (парламент)-ын гишүүнийг:

- Шууд сонгуулиар сонгодог-48 улс
- Шууд бус сонгуулиар сонгодог -3 улс

Ерөнхийлөгчийг:

- Ерөнхийлөгчийг бүх нийтийн 2 үе шат бүхий сонгуулиар сонгодог 15 улс,
- Ерөнхийлөгчийг Бүх нийтийн энгийн олонхын саналаар сонгодог 4 улс,
- Ерөнхийлөгчийг хууль тогтоох дээд байгууллагаас сонгодог 26 улс,
- Ерөнхийлөгчийг Сонгогчдын коллеги болон Сонгуулийн хорооноос сонгодог 6 улс байна.

Хууль тогтоох дээд байгууллагын хувьд, судалгаанд авагдсан 51 орноос 37 нь Парламентын нэг танхимтай, 14 нь Парламентын хоёр танхимтай улс орнууд байна.

Эрх зүйн бүл, төрийн удирдлагын хэлбэр, парламентын танхимын тоо, Ерөнхийлөгч болон хууль тогтоох дээд байгууллагыг сонгох зарчмын хувьд авч үзвэл Болгар, Финланд, Серби, Чрна Гора, Хорват, Исланд, Сингапур, Словак, Турк, Македон, Кыргызстан зэрэг улсууд Монгол улстай харьцангуй ижил зохицуулалттай байгаа нь судалгаанаас харагдсан.

Парламентын 2 танхимтай орны хувьд доод танхимыг **шууд сонгуулиар** сонгодог бол дээд танхимыг **шууд** болон **шууд бус сонгуулиар** сонгож байна. Зарим улс орны хувьд дараах онцлогтой байна. Тухайлбал,

- Ботсван Улсын Парламентын дээд танхимыг үе залгамжлуулан буюу томилдог;
- Герман Улсын Парламентын дээд танхимыг муж улсын төлөөллөөс сонгодог;
- Ирланд Улсын Парламентын дээд танхимыг намаас нэрийн жагсаалтаар томилдог;

- Словени Улсын Парламентын дээд танхимыг сонирхлын бүлгийн төлөөллөөс болон бүх ард түмнээс сонгодог байна.

Эдгээр орнуудаас хууль тогтоох дээд байгууллагыг бүх ард нийтээс сонгодоггүй нэг улс байгаа нь Ливи Улс /Парламентын нэг танхимтай/ бөгөөд Парламентыг Төлөөлөгчдийн зөвлөл /*Council of Representatives*-өөс сонгодог бол Вануату, Герман, Итали, Пакистан, Тринидад Тобаго, Энэтхэг зэрэг 6 улсад Ерөнхийлөгчийг “Сонгогчдын коллеги” болон “Сонгуулийн хороо” гэх бие даасан субъектээс сонгодог байна. **Сонгогчдын коллеги** болон **Сонгуулийн хороо** нь Парламентын гишүүн болон орон нутгийн төлөөллөөс бүрдсэн бие даасан байгууллага юм.

УИХ-ЫН ТАМГЫН ГАЗРЫН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГААНЫ АЛБА